



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/68

Хэрлэн сум

Төлөвлөгөө баталж,
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорингуравдугаар хуралдааны 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.3.2-д заасан "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" арга хэмжээг зохион байгуулах зардалд зориулж 10,000,000 (арван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, төсвийн тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

**"БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙН
БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД
2024 ОНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Аймгийн Засаг даргын
Дугээр сарын 08 -ны
Дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

№	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Хариуцах байгууллага
1.	<p>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран ажиллах</p> <p>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын "Өрсөлдөөн – Хэрэглэгчийн эрх орон нутагт" арга хэмжээний хүрээнд Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг (НҮТББ) - тэй хамтран ажиллах, хяналт шалгалтын арга хэмжээ зохион байгуулах</p>	1-4 дүгээр улиралд	<p>Өдөрлөг зохион байгуулагдсан байна.</p> <p>Зөрчил, дутагдлыг арилгуулж, арга хэмжээ зохион байгуулсан байна.</p>	ХЭЗХ
2.	<p>Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль Нийгмийн даатгалын тухай багц хууль тогтоомжийг сурталчлах, хүний эрх, хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг холбогдох байгууллага болон төрийн бус байгууллагатай хамтарч зохион байгуулах</p>	1-4 дүгээр улиралд	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	ХЭЗХ
3.	<p>Эрх зүйн хөтөөр бэлтгэсэн хөтөч ажилтнуудад давтан сургалт зохион байгуулах, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран ажиллах</p>	1-4 дүгээр улиралд	Хөтөч нар иргэдэд сургалт зохион байгуулах эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	ХЭЗХ
4.	<p>Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль Зөрчлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хуулиар гарын авлага, шторк, мэдээлэл бэлтгэх</p>	1-4 дүгээр улиралд	Иргэдийн хууль, эрх зүйн боловсрол мэдлэг дээшилсэн байна.	ХЭЗХ

**"БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙН
БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД
2024 ОНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨСӨВ**



Аймгийн Засаг даргын
дүгээр сарын 02-ны
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

№	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Санхүүжүүлэх эх үүсвэр /сая төгрөг/	Хариуцах байгууллага
1.	<p>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран ажиллах</p> <p>Хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөрлөг зохион байгуулах</p> <p>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын "Өрсөлдөөн – Хэрэглэгчийн эрх орон нутагт" арга хэмжээний хүрээнд Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг (НҮТББ)-тэй хамтран ажиллах, хяналт шалгалтын арга хэмжээ зохион байгуулах</p>	1-4 дүгээр улиралд	<p>Өдөрлөг зохион байгуулагдсан байна.</p> <p>Зөрчил, дутагдлыг арилгуулж, арга хэмжээ зохион байгуулсан байна.</p>	1.000.000	ХЭЗХ
2.	<p>Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль Нийгмийн даатгалын тухай багц хууль тогтоомжийг сурталчлах, хүний эрх, хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг холбогдох байгууллага болон төрийн бус байгууллагатай хамтарч зохион байгуулах</p>	1-4 дүгээр улиралд	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	3.000.000	ХЭЗХ
3.	<p>Эрх зүйн хөтөөр бэлтгэсэн хөтөч ажилтнуудад давтан сургалт зохион байгуулах, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран ажиллах</p>	1-4 дүгээр улиралд	Хөтөч нар иргэдэд сургалт зохион байгуулах эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	1.000.000	ХЭЗХ
4.	<p>Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль Зөрчлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Иргэний хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, Хөдөлмөрийн тухай хуулиар гарын авлага, шторж, мэдээлэл бэлтгэх</p>	1-4 дүгээр улиралд	Иргэдийн хууль, эрх зүйн боловсрол мэдлэг дээшилсэн байна.	3.000.000	ХЭЗХ
	Нийт			10.000.000	